



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 6/37

Улаанбаатар хот

「 Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын
мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт,
түүнийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтныг
шинэчлэн томилох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, мөн зүйлийн 8.4 дэх хэсэг, Авлигийн эсрэг хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 5 дугаар тогтоолоор баталсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан Шинэ бүтээл, ашигтай загварын шинжээч Б.Одгэрэлийг 2020 ны 5 дугаар сарын 29-ний өдрөөр тасалбар болгон эрх бүхий албан тушаалтнаас чөлөөлж Гадаад харилцааны мэргэжилтэн Зоригтбаатарын Гэрэлмааг 2020 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнаар томилсугай.

2. З.Гэрэлмаад 2020 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн сар бүр албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар тооцож нэмэгдэл олгохыг нягтлан бодогч /Э.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

3. Авлигийн эсрэг хууль болон бусад холбогдох журам, зөвлөмжийг чанд мөрдөж ажиллахыг З.Гэрэлмаад үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.АЗБАЯР